БАТЛАВ
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ Ц.ГАНСҮХ

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 27-НЫ ӨДӨР

ХӨВСГӨЛ АЙМАГ ТАРИАЛАН СУМЫН НЭГДСЭН ДУЛААН, ЦЭВЭР УСАН ХАНГАМЖ, ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖ, ТӨВЛӨРСӨН БОХИР УСНЫ ШУГАМЫН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР

2024.12.27 Дугаар ЗД-2024/72 Мөрөн

1	Зураг төсөл боловсруулах үндэслэл:	- Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит III хуралдааны III/31 дүгээр тогтоол, Аймгийн Засаг даргын 2024 оны А/686 дугаар захирамж - Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр - Хөвсгөл аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл **Зорилго:** - Тариалан сумын нэгдсэн дулаан, цэвэр усан хангамжийн эх үүсвэр, цэвэрлэх байгууламж бохирын шугам сүлжээнд холбох ажлыг эдийн засгийн хувьд үр ашигтай, төлөвлөлтийн хувьд оновчтой байдлаар тооцоолон төлөвлөх
2	Төлөвлөлтийн байршил, хамрах хүрээ Зориулалт, хүчин чадал, ачаалал	Байршил: Хөвсгөл аймгийн баруун хэсэгт Улаанбаатар хотоос 565км, аймгийн төвөөс 160 км зайд байрладаг. Сумын төвд 3024 хүн амьдардаг. **Инженерийн шугам сүлжээ түүнийг хангах эх үүсвэр:** - Одоо байгаа төвлөрсөн дулаан хангамжийн эх үүсвэр, дулааны 3 хос шугамыг өргөтгөж бүрэн шинэчлэх. Одоо байгаа цэвэр усны эх үүсвэр, төв шугамыг бүрэн шинэчлэх - Нэгдсэн дулааны эх үүсвэрийг сумын төвөөс гаргаж шинээр төлөвлөх - Сумын төвийн уст цэгийн судалгаа хийж цэвэр усны эх үүсвэрийн худаг гаргах. Хамгаалалтын бүс тогтоож орчноос тусгаарлах хашаа барих - Цэвэр усны эх үүсвэрийн худгийн барилга , нөөцийн усан сангийн барилга төлөвлөх - Нэгдсэн бохир усны шугамыг төлөвлөх ба хэрэглэгийн хүчин чадал болон хүн өсөн нэмэгдэх хэрэглээг тооцож цэвэрлэх байгууламж төлөвлөх - Дулааны эх үүсвар, цэвэрлэх байгууламж, цэвэр усны эх үүсвэрийн барилгуудын гадна цахилгаан хангамжийн ажил

		- Тариалан сумын дулаан хэрэглэгчид болон цаашид өсөн нэмэгдэх хэрэглээг тооцож дулааны шугам сүлжээний трассыг оновчтой төлөвлөх.
3	Зориулалт, хүчин чадал, ачаалал	**Инженерийн байгууламж** - Одоо байгаа төвлөрсөн дулаан хангамжийн эх үүсвэр, дулааны 3 хос шугамыг бүрэн шинэчлэн нийгмийн хамгааллын барилгууд, аж ахуйн нэгж, айл өрхүүдийг холбохоор хийх. - Нэгдсэн дулааны эх үүсвэрийн барилгыг цэвэр усны эх үүсвэрийн байршлаас шалтгаалан шинээр төлөвлөх - Цэвэр усны эх үүсвэрийн худгийн болон нөөцийн усан сангийн барилга төлөвлөх - Ус цэвэршүүлэх төхөөрөмж 2 ширхэг - Цэвэр усны 50 тоннын нөөцийн сав 2 ширхэгийг төлөвлөх - Цэвэр усны бичил лаборатори төлөвлөх - Нэгдсэн бохир усны шугамын ажлыг гүйцэтгэж хоногт 50-150 м3/хоног хүчин чадал бүхий цэвэрлэх байгууламж төлөвлөх - Бохирын төв шугамыг шинээр төлөвлөх - Төвлөрсөн дулаан, цэвэрлэх байгууламж, цэвэр усны эх үүсвэрийн барилгуудын гадна цахилгаан хангамжийг техникийн нөхцлийн дагуу төлөвлөх - Инженерийн шугам сүлжээний дагуу өндөржилттэй зураг хийж мэдээллийн санд бүртгүүлэх - Дулаан хангамжийн эх үүсвэр, түүний үндсэн болон туслах тоноглол сүлжээний усны насос, ус боловсруулах систем, ялтсан дулаан солилцуур зэргийг оновчтой, нөөцтэй байхаар тооцооллыг хийж тусгах
4	Ажиллах горим	- Байнгын ажиллагаатай
5	Санхүүжилтийн эх үүсвэр	- Улсын төсвийн хөрөнгө оруулалт
6	Төслийн ажлын үе шат	- 2 үе шаттай - Ус цэгийн судалгаа хийх - Ажлын зураг төсөв боловсруулж батлуулах
7	Төсөл гүйцэтгэхэд ашиглах норм дүрэм, стандарт	Монгол Улсын хуулиуд: - Газрын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, - Барилгын тухай хууль: - Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, - Хот байгуулалтын тухай хууль - Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хууль, - Байгаль орчныг хамгаалах тухай хууль - Усны тухай хууль - Эрчим хүчний тухай хууль - Салбаруудын хэмжээнд хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүд - Бусад хууль тогтоомж

		- Тариалан сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө /Хөгжлийн ерөнхий төлөвлөгөг шинэчлэх/ Монгол Улсын стандарт, норм нормативууд: - Хот, тосгоны төлөвлөлт барилгажилт БНбД 30-01-04 - Барилга байгууламжийн инженер геологийн судалгаа БД 11-102-07 - Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах,зөвшилцөх, магадлал хийх дүрэм - Ус хангамж. Гадна сүлжээ ба байгууламж БНбД 40-02-06 - Барилга доторх ус хангамж, ариутгах татуурга 40-05-16 - Цахилгаан байгууламжийн дүрэм Б343-101-03 - Авто зам төлөвлөх 33БНбД 22-004-2016 - "Барилга байгууламжийн галын аюулгүйн байдал" БНбД 21-01-02 - "Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм" БНбД 21-02-02 - "Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж дохиоллын хэрэгсэл" БНбД 21-04-05 - Техникийн нөхцөл - Дулааны сүлжээ БНбД 41-02-13 - Халаалт, агаар сэлгэлт, кондиционер БНбД 41-01-11 - Барилгад хэрэглэгдэх уур амьсгал геофизикийн үзүүлэлт БНбД 23-01-09 - Зуухны тоног төхөөрөмж БНбД 41-03-13 - Дулаан шугам сүлжээ. Ажлын зураг. Дулаан механикийн хэсэг. MNS 3238 : 2001 - Цэвдэгтэй бүс нутагт барилга, байгууламж төлөвлөх норм ба дүрэм - Бусад холбогдох норм, дүрэм, стандарт, заавар - Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө <u>Судалгааны материалууд:</u> - Орон нутагт хийгдсэн инженерийн нэгдсэн шугам сүлжээнд холбогдох барилга байгууламжуудын судалгааны материалууд
8	Зураг төсөл гүйцэтгэх хугацаа	Захиалагч, зөвлөх үйлчилгээ үзүүлэгч талуудын хооронд байгуулсан гэрээнд хугацааг тодорхой заасан байна.
9	Төслийг захиалагч	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газар
10	Төсөл боловсруулах байгууллага	Зөвлөх үйлчилгээ үзүүлэх байгууллага нь тухайн чиглэлийн зураг төсөл, боловсруулах тусгай зөвшөөрөлтэй, ажлын туршлагатай байна. / Ус хангамж, Ариутгах татуургын гол шугам сүлжээ, дулаан хангамжийн төвлөрсөн шугам сүлжээний угсралтын ажил, түүнтэй холбогдох барилга байгууламжийн технологийн ажлын зураг/

11	Төсөл хэрэгжүүлэгч байгууллага	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулалтаар шалгарсан байгууллага.
12	Ажлын зураг төслийн иж бүрдэл, тавигдах шаардлага	**Баримт бичгийн иж бүрдэл:** - Инженерийн геологийн дүгнэлт - Байр зүйн дэвсгэр зураг боловсруулах - Уст цэгийн судалгааны тайлан - Иж бүрэн ажлын зургийг холбогдох байгууллагуудтай зөвшилцөх, батлуулан, магадлал хийгдсэн байх - Магадлалаар баталгаажуулсан иж бүрэн ажлын зураг, батлагдсан төсвийг эх хувиар нь файлаар /CD/-1 хувь, цаасаар 3 хувь бэлтгэж, хүлээлгэн өгөх.
13	Төсөл боловсруулах үе шат	- Бодит байдлын талаарх судалгаа хийх /гадна шугамын одоогийн нөхцөл байдал, хэрэглэгчдийн судалгаа гэх мэт/ - Захиалагч талын төлөөлөлтэй зөвшилцөх - Хангагч талын гаргаж өгсөн техникийн нөхцөлүүд, холбогдох БНбД-д заасны дагуу ажлын зураг, төслийг боловсруулах. - Ажлын зурагт магадлал буюу экспертиз хийлгэх. - Зураг төслийн дагуу гадна шугамын барилга, угсралтын ажилд шаардагдах зардлын хяналтын төсвийг гаргах.
14	Зураг төсөл боловсруулах байгууллага	Зөвлөх үйлчилгээний эрх бүхий хуулийн этгээд
15	Эдийн засгийн тооцоо, төсөв	Зураг төсөлд тусгагдсан шугам сүлжээний ажилбар тус бүрээр ажлын төсөв боловсруулах ба нэгдсэн төсвийн нэгтгэл хүснэгтээр нийт хөрөнгө оруулалтын ажлыг нэгтгэж төсөвлөнө. Эдийн засгийн тооцоо болон төсвийг БНбД 81-95-12 болон ESTIMATOR – PRO программ ба түүнтэй ижил, цалинг дундаж зэргээр тооцдог, зохих эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн бусад программаар тооцно. /Шинэчилсэн программаар төсвийг бодсон байх шаардлагатай/
16	Зөвшилцөх байгууллага	- Хөвсгөл аймгийн ЗДТГ, ГХБХБГазар, Тариалан сумын Засаг дарга, ЗДТГ, Аймгийн ерөнхий архитектор болон холбогдох байгууллагатай зөвшилцөх. - Төлөвлөлтийн үе шатанд аймгийн ЗДТГ, ГХБХБГ, Тариалан сумын Засаг дарга,ЗДТГ, Инженерийн шугам сүлжээний хангагч байгууллагуудтай нэгдсэн уулзалт зохион байгуулж, санал авах - Төлөвлөгөөний баримт бичигт, магадлалын нэгдсэн дүгнэлт гаргуулах.
17	Инженерийн дэд бүтцэд тавигдах шаардлага	Зураг төсөлд холбогдох БНбД-үүд техникийн нөхцөл шаардлагын хүрээнд инженерийн шугам сүлжээнд нэвтэрч буй шинэ дэвшилтэт материалыг ашиглахаар тусгах.

18	Зураг төсөл боловсруулахад ашиглах материал	Тариалан сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулах. Мөн тухайн газрын хөрсний шинжилгээ, газар хөдлөлийн балл зэргийг тодорхойлох судалгааны дүгнэлтийг ашиглах.
19	Төслийн иж бүрдэл	- Инженер геологийн дүгнэлт - Геодезийн мэргэжлийн байгууллагаар гаргуулсан инженерийн шугам сүлжээний өндөржилттэй зураг - Уст цэгийн судалгааны тайлан - Гадна инженерийн шугам, сүлжээний ажлын зураг /магадлал хийгдсэн/ - Хяналтын төсөв
20	Төслийн онцгой нөхцөл /Төлөвлөлтийн шаардлагаар гарах нэмэлт шаардлагууд, трассын дагуух газар чөлөөлөх, хөрсний шинж чанараас хамаарсан нэмэлт төлөвлөлт, шинэ техник технологи хэрэглэх гэх мэт/	- Хэмжилтийг газар дээр нь хийж зураг төслийг гүйцэтгэх. - Инженерийн шугам сүлжээний тодруулга авч трассыг сонгох. - Газар хөдлөлтийн бүс нутагт барилга, байгууламж төлөвлөх барилгын норм ба дүрэм БНбД 22-01-01-ийн 2.5-ын 4-р хүснэгтийн 5-д заасан үндэслэлээр газар хөдлөлтийг тооцох - Инженерийн шугам сүлжээний трасс дагуу үерийн усны хамгаалах шуудуу, далангийн ажлыг төлөвлөх - Нийт хэрэглэгчийн ачаалал тооцсоны үндсэн дээр хүчин чадлыг зөв тохируулан төлөвлөх. - Шугам сүлжээ болон түүнтэй холбогдох барилга байгууламжийн угсралтын ажил гүйцэтгэхэд эдийн засгийн хувьд үр ашигтай орчин үеийн дэвшилтэт техник технологи нэвтрүүлэн ашиглахаар тусгаж өгөх. - Барилгын болон дулааны шугам хоорондын зайг "Эрчим хүчний шугам сүлжээ хамгаалах дүрэм"-ийн дагуу тусгасан байх. - Инженерийн шугам сүлжээний хамгаалалтын зурвас тогтоон төлөвлөлт хийх. - Дулааны шугам сүлжээг дайрч гарах зам талбай эвдэхэд тэдгээрийг сэргээх зардлыг төсөвт тусгах. - Гадна шугам сүлжээний ашиглаж болох хэсгийн угаалга, шахалт туршилтын зардлыг зураг төсөвт тусгах. - Батлагдсан ажлын зураг төслөөр угсралтын ажил гүйцэтгэх. - Аюулгүй ажиллагааг бүрэн хангасан байх - Шугамын трассын дагуу инженер геологийн дүгнэлт гаргасан байх - Инженер геологийн дүгнэлт, зураг, төсвийн үнийг төсөвт суулгасан байх
21	Байгаль орчны үнэлгээ	- Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэсэн байх

22	Галын аюулгүй байдал	-	“Барилга байгууламжийн галын аюулгүйн байдал” БНбД 21-01-02 “Барилга байгууламжийн зураг төсөл зохиох галын аюулгүйн норм” БНбД 21-02-02, “Барилга байгууламжийн гал унтраах автомат төхөөрөмж дохиоллын хэрэгсэл” БНбД21-04 шаардлага хангасан байна.

ХЯНАСАН:

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЕРӨНХИЙ АРХИТЕКТОР Э. АЗЗАЯА

ХӨВСГӨЛ ГХБХБГАЗРЫН ДАРГА Б.ГАНЗОРИГ

ЗУРГИЙН ДААЛГАВАР БОЛОВСРУУЛСАН:

ХӨВСГӨЛ ГХБХБГАЗРЫН БХБХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН Д.НЯМБАТ